



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

06.06 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 8/118

Мандалговь

Олон улсын хүүхдийн эрхийг
хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

Нэг. Коронавируст “Ковид-19” халдварт цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг гэр бүлийн хүрээнд “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан дор зохион байгуулсугай.

Хоёр. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Коронавируст “Ковид-19” халдварт цар тахлын аюулыг ойлгуулж, гэр бүлээрээ хамтдаа эрсдэл багатай даван туулахад гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, нөлөөлөл, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Удирдамжийн дагуу үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Сумдын Засаг дарга, Хүүхдийн төлөө аймаг, сумын зөвлөлийн гишүүд, албан байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа)-т үүрэг болгосугай.



482010417

Аймгийн Засаг даргын 2020 оны
05 дугаар сарын 18-ны өдрийн 1 дугаар
захирамжийн хавсралт

**КОРОНАВИРУСТ “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ
БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛАН ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ
ӨДРӨӨР НӨЛӨӨЛӨЛ, СУРТАЛЧИЛГАА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Зорилго: Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан, Коронавируст ковид-19 халдварт цар тахлын аюулыг ойлгуулж, гэр бүлээрээ хамтдаа эрсдэл багатай даван туулахад гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүл дэх хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчин бүрдүүлж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, дэмжих тэгш оролцоог хангахад оршино.

Уриа: “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай”

Хугацаа: “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” нөлөөлөл, сурталчилгааны ажлыг 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулах

Хамрах хүрээ: Дундговь аймгийн 15 сумын хэмжээнд

Үйл ажиллагааны чиглэл: Хүүхэд гэр бүлдээ жаргалтай нөлөөлөл сурталчилгааны ажлыг гэр бүлд сууринсан хүүхдийн эрхийг дээдлэх хандлагаар орон нутгийн хэмжээнд зохион байгуулна. Үүнд:

- Хүүхдийн эрхийн тухай, хүүхэд хамгааллын тухай хуулиудын эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагатай холбоотой зүйл, заалтыг сурталчилан таниулах
- Хүүхдийн эрхийг хангахад хуулиар үүрэг хүлээсэн хүүхдийн төлөө аймгийн болон сумын зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцогч талуудын оролцоог тэгш хангасан мэдээллүүдийг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах
- Хүүхэд, гэр бүлд зориулсан хөгжил, хамгаалал, цар тахлаас урьдчилан сэргийлэх цахим мэдээллийг бэлтгэж түгээх
- Аж ахуйн нэгж, байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинээр үүсгэн байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, тэдний гэр бүлд дэмжлэг үзүүлэх

Зохион байгуулалт:

- Сумын албан байгууллага, аж ахуй нэгжтэй хамтран ажиллах, орон нутгийн онцлог, хэрэгцээнд тохирсон шинэлэг ажлыг санаачлан хэрэгжүүлэх
- Хүүхдийн оролцооны байгууллагын санал санаачлагыг дэмжин хамтран ажиллах
- Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан олноор цугларах урлаг, уран сайхны арга хэмжээг зохион байгуулахгүй байх
- Цахим сүлжээ ашиглах
- Сонгуулийн сурталчилгаа, улс төрийн зорилготой үйл ажиллагаанаас ангид байх
- Удирдамжтай холбоотой асуудлаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Цэцэг /88048277/, Б.Бүжинлхам /89007954/, Ш.Эрдэнэсувд /90905616/, Б.Саранзая /86199978/ нараас тодруулах
- Удирдамжийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны тайлант 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дотор Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Пүрэвжаргалын able хаягаар ирүүлэх /99726614/

Зохион байгуулагдах үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтрах байгууллага
Нэг. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагатай холбоотой зүйл заалтыг сурталчлан таниулах;				
1.1	Хуулийг олон нийтэд сурталчлан таниулах нэлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж орон нутгийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах	2020.05.27-06.15	Аймаг, сумын хүүхдийн төлөө зөвлөл	Албан байгууллага, аж ахуй нэгжийн эцэг эхийн зөвлөлүүд
1.2	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас бэлтгэсэн урьдчилан сэргийлэх цахим контентуудыг олон нийтэд түгээх <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн эрхийн тухай хуулийг сурталчилсан онлайн постер /6/ • Шторк /2/ • Frame-1 	2020.05.27-06.15	Аймаг, сумын хүүхдийн төлөө зөвлөл	Албан байгууллага, аж ахуй нэгжийн эцэг эхийн зөвлөлүүд
Хоёр. Хүүхдийн төлөө аймаг, сумын зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцогч талуудын оролцоог тэгш хангасан мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах				
2.1	Аймаг, сумын хүүхдийн төлөө зөвлөлийн хурал зохион байгуулах бэлтгэлийг хангах, хуралдуулах	2020.05.27-06.15	ГБХЗХГ, Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Салбарын үүрэг хүлээгчид
2.2	Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлд ордог байгууллагын оролцоог олон нийтэд таниулах үйл ажиллагаа /ХТЗ-ийн гишүүдийн танилцуулга бүхий постер бэлтгэж, dundgobi.mn болон албан байгууллага, сумдын facebook, page хаягаар сурталчиллах /	2020.05.27-06.15	Аймаг, сумын хүүхдийн төлөө зөвлөл	Салбарын үүрэг хүлээгчид
Гурав. Хүүхдийн оролцооны байгууллагуудын санал санаачлагыг дэмжин хамтран ажиллах				
3.1	“Хүүхдээ сонсьё”, “Аз жаргалын микрофон” богино хэмжээний бичлэг хийж, цахимаар түгээх	2020.06.01	ГБХЗХГ, Залуучуудын хөгжлийн төв	Хүүхдийн оролцооны байгууллага
3.2	Сумын “Хүүхдийн элч”-ээр дамжуулан сурталчилгаа, нэлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах /Удирдамжийн дагуу/	2020.05.27-06.15	Сумын Засаг дарга	Хүүхдийн элч

Дөрөв. Аж ахуй нэгж байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинээр үүсгэн байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

4.1	Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд “БАЙГУУЛЛАГЫН ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ” шалгаруулах удирдамж, чиглэлийг хүргүүлж үйл ажиллагааг зохион байгуулах	2020.05.27-06.15	ГБХЗХГ, Сумын Засаг дарга	Байгууллагын эцэг эхийн зөвлөлүүд
4.2	Эцэг эхийн зөвлөлгүй аж ахуй нэгж, байгууллагуудад нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, шинээр үүсгэх /36 төрийн байгууллаг, ААН/	2020.05.27-06.15	Сумын Засаг дарга	Аймаг, сумын хүүхдийн төлөө зөвлөл
4.3	“Миний гэр бүлийн мөрөөдөл” цахим уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулах	2020.05.27-06.15	ГБХЗХГ	Байгууллагын гэр бүлийн зөвлөлүүд
4.4	“Үлгэрч аав ээж” цахим уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулах	2020.05.27-06.15	ГБХЗХГ	Байгууллагын гэр бүлийн зөвлөлүүд

Тав. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, тэдний гэр бүлд шууд болон шууд бус дэмжлэг үзүүлэх

5.1	<p>Хүүхэд гэр бүлд танин мэдэхүйн агуулга бүхий баярын бэлэг хүргүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Байнгын асаргаа сувилгаа шаардлагатай, хэвтрийн өвчтэй хүүхдэд /ХХҮГ-ын судалгаагаар аймгийн хэмжээнд 156 хүүхэд байна./ • Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд /2020 оны түргэвчилсэн үнэлгээгээр 886 өрхийн 1511 хүүхэд байна/ • Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж байгаа өрхийн хүүхдэд /270 өрх, сум бүрт 18 өрх/ • Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр шинээр мэндэлсэн хүүхдэд /10-15 хүүхэд/ 	2020.05.30-06.01	Сумын Засаг дарга	Албан байгууллага, аж ахуй нэгж, эцэг эхийн зөвлөлүүд
-----	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------	-------------------	-------------------------------------------------------